

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ “ШАТАР” ДЭД

ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

Монгол улсын Биеийн тамир спортын тухай хууль, Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2013-2016 оны “Шинэ Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Шатар”-н спортыг Булган аймагт хөгжүүлэх дэд хөтөлбөрийг аймгийн ИТХурлын III хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

“ОЮУНЛАГ БУЛГАНЧУУД-ШИНЭ БУЛГАНЫ ХӨГЖИЛ”-д уриалга дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа тус хөтөлбөр хэрэгжих хугацаандаа Оюуны спорт болсон Шатрыг хүүхэд багачууд, залуучууд, насанд хүрэгчид иргэд, олон нийт, байгууллагад хөгжүүлж үндэсний ёс заншил, уламжлалаа дээдэлсэн оюунлаг үзлийг төлөвшүүлэхэд оршиж байна.

Шатрын сургалт, сурталчилгаа, түүний хүрээнд зохион байгуулагдаж буй ажлыг Булган аймгийн 16 сум, 1 тосгон, 19 сургууль, 22 цэцэрлэгийн хүүхэд багачууд, залуучууд, нийт иргэдийн дунд зохион байгуулан ажиллаж байна.

Шатрын спортыг хөгжүүлэх түүний материаллаг баазыг бэхжүүлэх талаар сум байгууллага бүр өөрийн гэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байгаа нь шатрын спортыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа ажлуудаас тодорхой харагдаж байна.

2013-2015 онуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд орсоны дагуу Шатрын сургагч багш нарын 3 дахь удаагийн сургалтыг зохион байгуулан 15 сумын багш нар хамрагдан тэдгээр багш нарт дунд шатны хичээл заахад шаардагдах компьютерийн программ, ном товхимол, гарын авлагыг олголоо.

Мөн Ахмад багш Ж.Пүрэвсүрэн, ОУМ Ч.Хүрэлбаатар, багш Д.Энхмөнх нар хамтран Булган аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн шатрын мэдлэг олгоход зориулагдсан “Шатрын сурах бичиг”-ийг зохиож хэвлүүлэх сургалтанд хэрэглэж байна.

Зарим сумд сургууль, цэцэрлэгийн хүсэлтээр аймгийн болон Орхон, Улаанбаатар хотоос сургагч нар газар дээр нь хичээл зааж хүүхдүүдийг чадавхижуулах олон төрлийн ажлыг хийлээ.

2014 онд Булган аймгийн хэмжээнд болон бүс, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулахын зэрэгцээ баг тамирчдаа оролцуулсан байна. МУ-н “Шинэ үндсэн хууль” батлагдсаны нэрэмжит тэмцээн, Багийн шатрын аварга шалгаруулах тэмцээн, 500,1000 хүүхдийн шатрын тэмцээн, ОУМ Ч.Хүрэлбаатарын нэрэмжит олон хотын тэмцээн, МУ-н баатар Л.Дандарын нэрэмжит олон хотын тэмцээн, Насанд хүрэгчид, ахмадууд, өсвөр үеийн аймгийн аварга шалагруулах тэмцээн зэргээс гадна Тайвань улсад болсон Өсвөр үеийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн, БНХАУ-н Хөх хотод болсон “Монгол туургатан” хүүхдийн наадам, Багануурын өсвөр үеийн Олон улсын тэмцээн, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Улаанбаатар зэрэг газруудад болсон нээлттэй тэмцээнүүдэд амжилттай оролцоноос гадна Булган аймгаас анх удаа шатрын спортын төрлөөр 1-12 жилийн сурагч Н.Номин-Эрдэнэ Ази тивийн аваргын хүрэл медаль, ОУШХолбооны мастер цолыг 12 насандаа хүртсэн нь энэ жилийн гол үйл явдлын нэг байлаа. Мөн хөтөлбөрийн хүрээнд Шатрын аймгийн өсвөрийн шигшээ багийг 10 тамирчин 1 дасгалжуулагчтайгаар хичээллүүлэн урамшууллыг олгох ажлыг эхлээд байна.

2015 он хүртэлхи “Шатар” хөтөлбөрийн аймгийн хэмжээний тоо баримтаас дурдвал:

Насанд хүрэгчдийн хэмжээнд:

Булган аймгийн 16 сум, 1 тосгоны 18 дээш насны **38676** /58593/ байгаа нь нийт хүн амын **65%** эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн **11190** хүн буюу насанд хүрсэн хүний **29%** шатрын анхан

шатны мэдлэг эзэмшсэн нь 2013 оныхоос /16%-тай байсан/ **13%**-аар өссөн үзүүлэлт гарч байгаагийн **2913** нь 2014 онд шатрын анхан шатны мэдлэг эзэмшсэн байна. Нийт сум тосгоны хэмжээнд 2013 онд 20.3 сая төгрөгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан бол 2014, 2015 онуудад сумын ажлын хэсгүүдээс **29.631.000** төгрөгийг, ивээн тэтгэгч хандивлагчдаас **15.536.000** төгрөг нийт **45.167.000** төгрөгийг зарцуулсан байна.

2015 оны байдлаар сумдын хэмжээнд **200** удаагийн шатрын уралдаан тэмцээн зохион байгуулагдаж түүнд давхардсан тоогоор **5392** хүн хамрагдсан байна.

Сумдын 18 дээш насны шатар сонирхогчдоос **453** хүн аймаг бүсийн чанартай уралдаан тэмцээнүүдэд оролцсон байна. Баяннуур суманд “Хос морь”, Бугат суманд “Бэрс”, Булган суманд “Сөрт”, “Уран гараа”, Бүрэгхангай суманд “Алаг морьт”, Дашинчилэн суманд “Орхой”, Орхон суманд “Нүүдэлчин”, Сайхан суманд “Ламаадан”, Сэлэнгэ суманд “Ингэт”, Рашаант суманд “Цэцэнхүү”, Хялганат тосгонд “Бэрс” зэрэг 11 клуб нээгдэн ажиллаж байгаа бөгөөд бусад сумдад шатрын танхим хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Сумдын хэмжээнд Бугат сум 5.6 сая, Бүрэгхангай сум 13.5 сая, Хутаг-Өндөр сум 4.3 сая, Баяннуур сум 2.3 сая, Булган сум 3.2 сая, Орхон сум 2.8 сая, Хялганат тосгон 2.6 сая орчим төгрөгийг “Шатар” хөтөлбөрт жил бүр дунджаар тус тус зарцуулсан байна.

Сургуулийн насныханы хүрээнд:

Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 19 сургуулийн 8956 хүүхдийн **6299** буюу нийт суралцагсдын 70% шатрын анхан шатны мэдлэг эзэмшсэнээс 1228 сурагч дугуйлан секцэнд хамрагдаж 2537 хүүхэд анхан шатны мэдлэг эзэмшин 2534 хүүхэд дунд болон гүнгийрүүлсэн шатны мэдлэг эзэмшсэн байна. Энэ жил нийт сургуулиудын хэмжээнд **146** шатрын уралдаан тэмцээн зохион байгуулагдсан байна. 2013 онд “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулиудаас 8.190.000 төгрөг зарцуулж байсан бол 2014-2015 онуудад тус бүр сургуулиудаас **12.488.800** төгрөг, ивээн тэтгэгч хандивлагчдаас **11.393.600** төгрөг, нийт **23.881.800** төгрөгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

Сургуулийн хэмжээнд “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зохион байгуулсан онцлог ажлуудаас дурдвал: Сургууль бүр өөрсдийн шигшээ багтай болж анги танхим, дотуур байруудад шатартай болсноос гадна нийт багш нарыг шатрын анхан болон дунд шатны мэдлэгтэй болгох ажлуудыг зохион байгуулжээ. Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Гурванбулаг, Тэшиг, Хутаг-Өндөр, Булган зэрэг сумдад сургагч багш нарын цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэж /үндсэн болон цагийн багшаар/ сургалтын хөтөлбөрт оруулан 7 хоногт 2-6 цагийн хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулан хичээллүүлж байна.

Цэцэрлэгийн насныханы хүрээнд:

Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгт 2-6 насны **2642** хүүхдээс анхан шатны мэдлэг эзэмшсэн **526** байгаа нь нийт хүүхдийн **20%** болж байна. Цэцэрлэгийн насны хүүхдүүдээс өөртөө шатартай хүүхдийн тоо **450** болж нийт хүүхдийн **17%** эзэлж байна. Нийт цэцэрлэгүүд анги танхимаа тохижуулах, шатартай болох, эцэг эхчүүд хүүхдүүдийн дунд зохион байгуулах уралдаан тэмцээн зэрэгт нийт **3.438.500** төгрөгийг зарцуулж хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. Булган сумын 1-р цэцэрлэг 567.500, 6-р цэцэрлэг 300.000, Хутаг-Өндөр сумын цэцэрлэг 489.500, Хялганат тосгоны цэцэрлэг 531.500 төгрөгийг гэх зэргээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил бүр зарцуулжээ.

Аймгийн хэмжээгээр 2013-2015 онуудад “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд шатны анхан шатны мэдлэг эзэмшсэн болон шатраар хичээллэгч хүний тоо **18015** болсон нь нийт хүн амын **31% хамарсан** үзүүлэлт гарч байна. “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 3 жилийн ажлын хүрээнд Аймгийн ОНХСангаас **47,5 сая** төгрөг, сумдын ажлын хэсгүүдээс жил дунджаар **45.167.000** төгрөг, сургуулиудаас **23.881.000** төгрөг, цэцэрлэгүүдээс **3.438.500** төгрөг нийт аймгийн хэмжээнд шатар хөтөлбөрт **89.486.500** төгрөгийг зарцуулсан байна.